



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/09

Арвайхээр

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Орон нутгийн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх “Орон нутгийн урамшуулал олгох журам”-ыг эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах, дэмжих аймгийн дэд хөтөлбөртэй уялдуулан сурталчлах, хэрэгжүүлэх, удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. “Орон нутгийн урамшуулал олгох” тухай энэхүү журмыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, мөн өдрөөс эхлэн аймгийн Засаг даргын “Журам батлах тухай” 2013 оны а/128 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100017

Аймгийн Засаг даргын 2020 оны 01
дугаар сарын 15-ны өдрийн 409 дугаар
захирамжийн хавсралт



“ОРОН НУТГИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ”

Нийтлэг үндэслэл:

Энэхүү журмыг аймагт нэн шаардлагатай, дутагдалтай байгаа зарим нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэнд урамшуулал олгох, эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт очиж ажиллаж байгаа эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг хангах, онцгой хүнд тохиолдолд мэдлэг ур чадвараа дайчлан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлж хүний амь нас аварсан эмч, мэргэжилтнүүдийн багт аймгийн Засаг даргын нэрэмжит урамшуулал олгохтой холбогдон гарах харилцааг зохицуулахад дагаж мөрдөнө.

Нэг. Орон нутгийн урамшууллын төрлүүд:

1. Нэн шаардлагатай, дутагдалтай байгаа зарим нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэнд олгох урамшуулал;

2. Эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт очиж ажиллаж байгаа эмч, мэргэжилтний нийгмийн баталгааг хангахад үзүүлэх хөнгөлөлт, бусад дэмжлэг;

3. Онцгой хүнд тохиолдолд мэдлэг ур чадвараа дайчлан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлж хүний амь нас аварсан эмч, мэргэжилтнүүдийн багт олгох урамшуулал.

1.1. Нэн шаардлагатай, дутагдалтай байгаа зарим нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэнд олгох урамшуулал

1.1.1. Нэн шаардлагатай, дутагдалтай байгаа зарим нарийн мэргэшлийн эмч болон сувилагч ажиллуулах тухай сул ажлын байрны зарлалд заасан шаардлагад тэнцсэн тохиолдолд аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан, ажилласан эхний 3-5 жилд нь жил бүр урамшуулал олгоно.

Урамшуулалд дараахь мэргэшлүүд хамаарна.

1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд:

- Сэтгэц судлалын эмч;
- Сүрьеэгийн эмч, сувилагч;
- Эмгэг судлаач эмч, эмгэг судлалын туслах ажилтан;
- Бактерилогийн эмч, сувилагч;
- Эс судлаач эмч;
- Нярайн эмч, сувилагч;
- Халдвартын эмч /Бэлгийн замын халдварт өвчний чиглэлээр мэргэших/

2. Хархорины нэгдсэн эмнэлэгт:

- Дүрс оношилгооны эмч
- Сэтгэц судлалын эмч

3. Уянга, Бат-Өлзий, Хужирт, Богд сумдын эрүүл мэндийн төвд:

- Мэс заслын эмч, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулахын эмч;

- Дотор, мэдрэлийн эмч;
- Эх барих-эмэгтэйчүүдийн эмч;
- Хүүхдийн эмч.

4. Эрүүл мэндийн газарт:

- Эх барих-эмэгтэйчүүдийн эмч;
- Хүүхдийн эмч;
- Тархвар судлал, эрүүл ахуй судлал;
- Зарим эрүүл мэндийн байгууллагад нэн зайлшгүй шаардлагаар Эрүүл мэндийн газрын шийдвэрээр ажиллаж буй эх баригч, бага эмч, сувилагч.

1.2. Эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт очиж ажиллаж байгаа эмч, мэргэжилтний нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөнгөлөлт, дэмжлэг

1.2.1. Эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт Эрүүл мэндийн газар, тухайн сумын Засаг даргатай гэрээ байгуулан очиж ажиллаж байгаа эмч, мэргэжилтний нийгмийн баталгааг хангахад дараахь хөнгөлөлт, дэмжлэг хамаарна. Үүнд:

-Ажиллах хугацаанд нь орон байраар хангах болон бусад дэмжлэг, хөнгөлөлт;

-Эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан нарийн мэргэшил олгох сургалтад суралцаж байгаа эмч, мэргэжилтэнд суралцах хугацаанд нь үндсэн цалингийн 60-100 хувьтай тэнцэх цалинг олгох, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх;

-Тухайн орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, анагаахын чиглэлээр суралцах хүсэлтэй ахлах ангийн сурагчдыг дэмжих, бага эмч, сувилагчийг их эмчийн мэргэжил эзэмших сургуульд суралцахад нь, мөн төгсөх курсийн оюутны төлбөрт гэрээний үндсэн дээр дэмжлэг үзүүлэх.

1.2.2. Эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт очиж ажиллаж байгаа эмч, мэргэжилтний нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөнгөлөлт, дэмжлэгийг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, Засаг даргын шийдвэрээр олгож болно.

1.3. Онцгой хүнд тохиолдолд мэдлэг ур чадвараа дайчлан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлж хүний амь нас аварсан эмч, мэргэжилтнүүдийн багт урамшуулал олгох

1.3.1 Эмч, мэргэжилтнүүд онцгой хүнд тохиолдолд оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг баримтлан тусламж үйлчилгээ үзүүлсний үр дүнд хүний амь нас аварсан тухайгаа холбогдох анхан шатны маягтуудыг үнэн зөв хөтөлж, тухайн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ хариуцсан дарга, эмчид тухай бүрт нь мэдээлж, бүртгүүлнэ.

1.3.2. Тухайн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ хариуцсан дарга, эмч чанарын албаар нь жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор "Онцгой хүнд тохиолдолд хүний амь нас аварсан тохиолдол"-уудыг оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжуудад батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хэлэлцүүлэн үнэлж, холбогдох материалыг Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

1.3.3. Эрүүл мэндийн газар нь онцгой хүнд тохиолдолд хүний амь нас аварсан тохиолдлын үнэн зөвийг тогтоон хэлэлцэж дүгнэлт, санал гаргана.

Хоёр. Урамшуулал, хөнгөлөлт, дэмжлэгийн дээд хязгаар

2.1. Журмын 1.1-т заасан нэн зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтнүүдэд ажилласан эхний 3-5 жилд нь жил бүр 1.500.000 төгрөг (нэг сая таван зуун мянган төгрөг) хүртэл;

2.2. Журмын 1.2-т заасан эмч, мэргэжилтэн дутагдалтай байгаа хөдөө орон нутагт очиж ажилласан эмч, мэргэжилтэнд олгох хөнгөлөлт, бусад дэмжлэгт хязгаар тогтоохгүй. Тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал, Засаг даргын шийдвэрээр тогтоох;

2.3. Журмын 1.3-д заасан онцгой хүнд тохиолдолд мэдлэг ур чадвараа дайчлан, чанартай тусламж үйлчилгээ үзүүлж, хүний амь нас аварсан эмнэлгийн мэргэжилтний багт (жил тутамд 3 хүртэлх тохиолдолд) 1.500.000 төгрөг (нэг сая таван зуун мянган төгрөг) хүртэл.

Гурав. Урамшуулал олгох:

3.1. Эрүүл мэндийн газар нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор энэхүү журмын шаардлагыг хангасан эмч, мэргэжилтнүүдэд олгох урамшууллын саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлнэ.

-оОо-